



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 591

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 108,800,000.00 /нэг зуун найман сая найман зуун мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 4 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001152

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
591... дугаар тогтоолын хавсралт

Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргэн босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)	Балансад бүртгэлтэй байгаа байгууллагын нэр
1	Хундай Соната-6, 63- 52 ДГО, арал № КМННУ41ВР7А353062	2007/ 2012	200956	19,000,000.00	19,000,000.00	0	0	500,000.00	125,000.00	Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
2	Тоёота кровн, 80-84 БНХ, арал № GRS1800023107	2005/ 2012	158160	20,000,000.00	20,000,000.00	0	0	500,000.00	125,000.00	Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
3	Исузу Троопер, 44- 35 БУА, арал № JACD158X927J04430	2002/ 2011	82282	35,000,000.00	35,000,000.00	0	0	500,000.00	125,000.00	Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс
4	Ландкрийзер-100, 52- 54 УНН, арал № JT3HT05J3 W0013463	1998/ 2012	400000	34,800,000.00	34,800,000.00	0	0	4,800,000.00	1,200,000.00	Мэдээллийн технологийн төв
	Нийт дүн			108,800,000.00 /нэг зуун найман сая найман зуун мянган/	108,800,000.00 /нэг зуун найман сая найман зуун мянган/	0	0	2,500,000.00 /хоёр сая таван зуун мянган/		